



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 1523

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 91 дүгээр дүгнэлтийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Багийн төвийн барилга (Өвөрхангай, Баян-Өндөр, Өлзийт, Төгрөг сум) ЗГХЭГ/201902005 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Баян-Өндөр сумын багийн төв багцыг 62454473 (жаран хоёр сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгөөр Гуа-Орд ХХК-иар, багц-2 Өлзийт сумын багийн төв багцыг 62005094 (жаран хоёр сая таван мянга ерэн дөрөв) төгрөгөөр Амадо ХХК-иар, багц-3 Төгрөг сумын багийн төв багцыг 69849308 (жаран есөн сая найман зуун дөчин есөн мянга гурван зуун найм) төгрөгөөр Чусан ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБОЛД

011100922